



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.01.10 № 7/158

танай _____-ны № _____-т

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ
ТӨВИЙН ЗАХИРАЛ В.ОЮУМАА,
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Н.УУГАНБАЯР НАР
ТАНАА


“Журам батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/358, А/99 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүний төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-ын хуулбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт ... хуудастай.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА

Э.ЭНХТУЯА



151510006
А5 Файл.2023

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2022 оны 01 сарын 09-ны
өдрийн 01.07 дугаарт бүртгэв.

2022 оны 12 дугаар
сарын 19-ны өдөр

Дугаар 4358, А/99


Улаанбаатар
ХОТ

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүний төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Хууль зүйн туслалцааны төвийн захирал (В.Оюумаа)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (П.Сайнзориг), Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Н.Анхбаяр) нарт үүрэг болгосугай.





ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАЛАЛГҮЙ ХҮНИЙ ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ БАЙДЛЫГ ТОГТООХ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүний төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, холбогдох бусад байгууллагаас гадаадын иргэн, харьяалалгүй хүний талаарх мэдээллийг солилцож, хамтран ажиллана.

Хоёр.Хууль зүйн туслалцаа үзүүлэх

2.1.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.3-т заасан хүрээнд хууль зүйн туслалцаа үзүүлнэ.

2.2.Энэ журмын 2.1-д зааснаас бусад хэрэг, маргаанд дор дурдсан тохиолдолд хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлж болно.

2.2.1.Монгол Улсын олон улсын гэрээнд хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авна гэж заасан бол;

2.2.2.эрх бүхий байгууллага нь тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүний төлбөрийн чадваргүй байдлыг тодорхойлж, хууль зүйн туслалцаа хүссэн албан бичгийг ирүүлсэн бол;


2.2.3.үйлчлүүлэгчийн төлбөрийн чадваргүй байдлыг тодорхойлсон Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын тодорхойлолт болон холбогдох нотлох баримт бичгийг ирүүлсэн бол.

Гурав.Эрх, үүрэг

3.1.Үйлчлүүлэгч нь дараах эрх эдэлж, үүргийг хүлээнэ.

3.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалах улстай байгуулсан тэрээгээр тогтоосон эрх эдэлж, үүргийг хүлээх;

3.1.2.үйлчлүүлэгч нь төлбөрийн чадваргүй болохоо үнэн зөв мэдүүлэх, холбогдох нотлох баримт бичиг, тодорхойлолтыг гаргаж өгөх.



3.1.3.хуульд заасан бусад эрх, үүрэг.

3.2.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2.1.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь хууль зүйн туслалцаа авах өргөдөл гаргасан үйлчлүүлэгчийн харьяалах улс болон холбогдох гэрээний хэлэлцэн тохирогч бусад улсын эрх бүхий байгууллагад хандаж үйлчлүүлэгчийн санхүүгийн байдлын талаарх мэдээлэл авах;

3.2.2.хуульд заасан бусад.

3.3.Холбогдох бусад байгууллага дараах эрх эдэлж, үүргийг хүлээнэ.

3.3.1.Сум, хорооны Засаг дарга нь бүрэн эрхийн хүрээнд үйлчлүүлэгчийн талаарх шаардлагатай тодорхойлолт, мэдээллийг хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагад үнэн зөв гаргаж өгөх;

3.3.2.хуульд заасан бусад эрх, үүрэг.

Дөрөв.Хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах үндэслэл

4.1.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь үйлчлүүлэгчийн өргөдөлд дараах үндэслэлээр үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан шийдвэрийг гаргана.

4.1.1.Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн бол;

4.1.2.Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт заасан хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх хүрээнд хамаарахгүй бол.

Тав.Орчуулагч, хэлмэрч оролцуулах

5.1.Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд орчуулагч, хэлмэрч оролцуулж болно.

5.2.Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд оролцох орчуулагч, хэлмэрчийн хөлсийг хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын төсөвт тусган батлуулна.

Зургаа.Бусад

7.1.Үйлчлүүлэгч нь төлбөрийн чадваргүй байдлаа тодорхойлохдоо хуурамч баримт бичиг үйлдсэн, бүрдүүлсэн бол Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

7.2.Орчуулагч, хэлмэрч үнэн зөв орчуулах, хэлмэрчлэх үүрэгтэй бөгөөд зориуд худал орчуулж, хэлмэрчилбэл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

--оОо--

